



“ЗАМ, ДЭД БҮТЭЦ - ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ”

Сургалт, туршлага судлах аялал

Зорилго:

Манай эрин цагийн том шалгуур- уур амьсгалын өөрчлөлт биднээс шинэ хандлага, бизнесийн арга барил шаардсаар байгаа билээ. Харин 2020оноос цэнхэр гарагт бий болсон цар тахлын гэнэтийн сорилтууд биднийг бүхий л талаар амьдралын, бизнесийн эрс өөрчлөлт хийхийг шаардаж байна. Эдгээр сорилтуудыг бид хамтран бие биеээсээ суралцах, харилцан нөхөх замаар туулах учир ийм хэлбэрийн солилцооны ач холбогдол өндөр. Дэлхийн хамтын нийгэмлэг, Монгол улсын нэгдмэл тогтвортой хөгжлийн зорилтуудыг бүх талаар хариуцлагатай хэрэгжүүлэхэд дэд бүтцийн салбар, салбарын ААН-н чадамжийг сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд нөлөөлөл бий болгоход сургалт – аялалын зорилго оршино.

Агуулга:

- Тогтвортой хөгжлийн бодлого барилгын салбарт - Төрийн бодлого, хэрэгжилт
- Тогтвортой хөгжлийн баримтлал - эргэлтийн эдийн засаг
- Туслан гүйцэтгэлийн менежмент
- ААН-н хөгжил, арга зүйн чадамж

Хамрах хүрээ:

- Салбарын ААН-үүдийн удирдах түвшиний төлөөлөл,
- Салбарын бодлого, зохицуулалтын байгууллагын төлөөлөл,
- Салбарын мэргэжлийн үндсэн болон мэргэжил дээшлүүлэх сургалт, судалгааны байгууллагын төлөөлөл

Хүлээх үр дүн:

Эрдэсийн түүхий эдийн хамгийн том хамаарал бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалтын салбарт хязгаарлагдмал нөөцийн хэмнэлт, сэргээгдэх нөөцийн өндөр ашиглалт бүхий агаарын болон хөрсний бохирдолоос сэргийлэхүйц маргаашийн эринд хохирол үл учруулах хариуцлагатай, тогтвортой байдлыг хэрхэн хангаж буй талаар ХБНГУ-ын тэргүүлэх арга, туршлагаас суралцах,

Ногоон хөгжлийн зорилго, зорилтуудад нийцсэн хот, хот байгуулалтын бодлого, бодлогын хэрэгжилтийн арга зам, дэмжлэгүүдийн талаар туршлага судлах,

нөөцийн хэмнэлт бүхий дэвшилтэт технологиудтай танилцах, суралцах

Үйлдвэрлэл үйлчилгээний бүтээмж дээшлүүлэх арга замуудаас суралцах,

Үндэсний бөгөөд олон улсад өрсөлдөх чадварыг өсгөх арга замуудад суралцах



ХӨТӨЛБӨР

1.өдөр	2022.04.09	Бямба
13:50	Франкфурт хотноо хүрэлцэн ирэх	
16:30	Өдрийн хоол	
17:00-19:00	Франкфурт ам Майн хоттой танилцах	
18:00	Зочид буудалд буух, алжаал тайлах	
2.өдөр	2022.04.10	Ням
06:30-07:30	Өглөөний цай	
07:30-08:30	Мэдээлэл, танилцуулга арга хэмжээ	
	<ul style="list-style-type: none">• ТӨВД агентур - танилцуулга• Сургалт, туршлага судлах аялалын хөтөлбөр, өртөөнүүд• Хүн бүр элч – олон улсын бизнес харилцааны чадамж	
09:00-12:00	Франкфурт ам Майн – Ваймэр	
12:00-13:00	Өдрийн хоол	
13:30-15:00	Ваймэр хот, Бухэнвалд -н дурсгалын цогцолбортой танилцах	
15:00-17:00	Ваймэр – Халлэ	
	Халлэ хотод зочид буудалд бууж амрах	
3. өдөр	2022.04.11	Даваа
07:30-08:00	Өглөөний цай	
09:00-12:00	Холбооны хурданы зам ТӨХХК – зүүн бүсийн салбарт хийх, мэдээлэл, экскурс арга хэмжээ	
	<ul style="list-style-type: none">- Холбооны хурдны замын бүтэц, тогтолцоо- Хурданы замын аюулгүй байдал, тоноглол- Хурдны замын арчилгаа, үйлчилгээ	
12:30-13:30	Өдрийн хоол	
14:00-16:00	Хурданы замын хөдөлгөөний зохицуулах төв - экскурс	
18:00	Зочид буудалд буух, амрах	
4. өдөр	2022.04.12	Мягмар
07:30-08:30	Өглөөний цай	
09:30-12:30	Раренбург групп -туршлага судлах мэдээлэл арга хэмжээ	
	<ul style="list-style-type: none">- Концерны түүх- Үйл ажиллагааны чиглэлүүд, менежмент- Цаг үеийн сорилтууд, даван туулж буй арга замууд	
12:30-13:30	Өдрийн хоол	
14:00-16:30	Раренбург группын гүйцэтгэж буй инженерийн бүтээн байгуулалттай танилцах – экскурс	
16:30-19:00	Халлэ - Берлин	
19:00	Зочид буудалд буух, алжаал тайлах	



5. өдөр	2022.04.13	Лхагва
09:00-10:00	Өглөөний цай – Холбооны парламентын ордон Бүндэстаг-ийн зоогийн газарт	
10:30-12:30	Холбооны тээвэр, цахим дэд бүтцийн яам - ХБНГУ-ын автозам, тээврийн бодлого – мэдээлэл арга хэмжээ	
13:00-15:00	Шинээр тавьж буй хурдны замын гүйцэтгэл - экскурс • Хурдны зам төлөвлөлт - байгаль орчны нөлөөлөл, хамгаалал • Гүйцэтгэлийн хяналт	
15:30-16:30	Өдрийн хоол	
18:30-20:30	Урлагийн тоглолт үзэх	
6. өдөр	2022.04.14	Пүрэв
07:00-07:30	Өглөөний цай	
08:00-12:00	<i>Туслан гүйцэтгэгч/ ТГ/ сонгон шалгаруулалт, гэрээний эрх зүй</i> • ТГ-с ерөнхий гүйцэтгэгчийн нэр төр, зардалын эрсдэл шууд хамаарна • Хамтын ажиллагааны стратеги	
12:30-13.30	Өдрийн хоол	
13:30-16:00	<i>Туслан гүйцэтгэлийн / ТГ/ менежмент</i> • Хяналт /цагийн, зардалын, гүйцэтгэлийн/ • Хөдөлмөрийн мөлжлөг, албан бус хөдөлмөр эрхлэлттэй тэмцэх	
16:30 хойш	Чөлөөт цаг – барилгын материалын болон бусад төрлийн дэлгүүр	
7. өдөр	2022.04.15	Баасан
07:30-08:00	Өглөөний цай	
08:00-11:00	<i>Эргэлтийн эдийн засаг барилгын салбарт – семинар</i> - Нөөцийн хэмнэлт, түүхий эдийн эргэн ашиглалт	
12:30-13:30	Өдрийн хоол	
13:30 хойш	Чөлөөт хөтөлбөр – Потсдам хотоор аялах, худалдаа Эл өдөр бүх нийтийн амралтын өдөр учир дэлгүүр, хоршоод онгойхгүй	
8. өдөр	2022.04.16	Бямба
09:00-10:00	Өглөөний цай	
07:33-11:51	Берлин – Франкфурт ам Майн олон улсын нисэх буудал	
12:30	Нислэгийн бүртгэл	
15:30	Франкфурт ам Майн → Улаанбаатар	

Бүртгэл дуусах хугацаа: 2022.03.25

Визний мэдүүлэх хугацаа: 2022.03.28

Арга хэмжээний үнэ: Евро 1.870

Зардалд багтсан үйлчилгээ:

- ХБНГУ-д хөтөлбөрийн хүрээнд үйлчлэх тээврийн хэрэгсэл,
- Сургалт, экскурсын зардал,
- 7 х Зочид буудал /3-Аодтой буудалд 2хүний өрөөгөөр тооцсон болно, хэрэв нэг хүний өрөөнд орох бол €250,- нэмэгдэнэ/
- 7 х өглөөний цай,
- 7 х өдрийн хоол
- Бэлтгэл ажил- агуулга болон ложистик зохион байгуулалт,
- Гүйцэтгэл – зохион байгуулалт, хөтөч, орчуулга,
- Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал

Зардалд олон улсын нислэг, визний хураамж, оройн хоол багтаагүй болно.